



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 8.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Тус газрын харъяа Радио, телевизийн сүлжээ Улсын төсөвт үйлдвэрийн газар, Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газар, Мэдээллийн технологийн үндэсний парк зэрэг байгууллагуудын 2013 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын хэсгийн тайланг 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Б.Мөнхтулгад даалгасугай.

ДАРГА



Ц.ЖАДАМБАА

110167

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2013 оны 01 сарын 13 өдрийн
13 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Ажлын зорилго

Харъяа байгууллагуудын төр засгийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилт, тухайн байгууллагын 2013 онд тавьсан зорилт, хүрсэн үр дүн болон МТШХХГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт зэргийг хяналт-шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт гаргах, түүнийг үндэслэн цаашид авах арга, хэмжээ, хамтран хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойлоход оршино.

Хоёр. Ажлын хамрах хүрээ, хугацаа

Энэхүү ажлын хүрээнд Радио, телевизийн сүлжээ УТҮГ, Үндэсний Дата Төв, Мэдээллийн технологийн үндэсний парк зэрэг байгууллагууд хамрагдана.

Ажлын хэсэг тушаал гарсан өдрөөс 2014 оны 01 дүгээр сарын 28-ны хугацаанд ажиллана.

Гурав. Ажлын арга зүй

Энэхүү ажилд "Агентлагийн эрх зүйн байдлын тухай" хууль болон, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам" болон МТШХХГ-ын даргын 2010 оны 144 дүгээр тушаалаар батлагдсан "Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын болон харъяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээний биелэлтийг дүгнэх, урамшуулал олгох" журмыг тус тус баримтална.

Ажлын хэсгийн гишүүд харъяа байгууллагын жилийн үйл ажиллагааны тайлан, агентлагийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, салбарын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийгэм эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд хамаарах ажил үүргийн хэрэгжилт зэргийг урьдчилан гаргуулж танилцсан байх ба хяналт-шинжилгээний асуудлаар тодруулга, тайлбар авах, байгууллагын үйл ажиллагаатай танилцах зорилгоор доорхи хуваарийн дагуу ажиллана.

Байгууллагуудад ажиллах хуваарьт өдрөөс өмнө байгууллагуудад урьдчилан мэдэгдэж шаардлагатай танилцуулга, материалыг бэлдүүлнэ.

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2014 оны 01 сарын 13 өдрийн
13 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН 5202965

Ажлын хэсгийн
ахлагч:

Б.Мөнхтулга, Хяналт-шинжилгээний газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ажлын хэсгийн
нарийн бичиг:

Э.Бат-Оюун, Хяналт-шинжилгээний газрын
мэргэжилтэн

Ажлын хэсгийн
гишүүд:

Б.Алтансүх, Төрийн захиргааны удирдлага, хамтын
ажиллагааны газрын дарга

Б.Цэцэг, Хяналт-шинжилгээний газрын ахлах
мэргэжилтэн

Э.Бямбасүрэн, Мэдээллийн технологи, инновацийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Р.Алтангэрэл, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах
газрын ахлах мэргэжилтэн

Ш.Хандмаа, Төрийн захиргааны удирдлага хамтын
ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн

В.Батбаяр, Шинэчлэлтийн бодлогын төлөвлөлтийн
газрын Сансар, радио холбооны хэлтсийн ахлах
мэргэжилтэн

Б.Оюунцэцэг, Шинэчлэлтийн бодлогын
төлөвлөлтийн газрын Сансар, радио холбооны
хэлтсийн мэргэжилтэн

Б.Солонго, Хяналт-шинжилгээний газрын
мэргэжилтэн

М.Нямтуяа, Харилцаа холбоо, дэвшилтэт
технологийн ажлын албаны мэргэжилтэн

Б.Бямбасүрэн, МТШХХГ-ын Ерөнхий нягтлан бодогч

Э.Хонгорзул, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн
сангийн ажлын албаны нягтлан бодогч

Дөрөв. Ажлын хэсгийн байгууллагуудад ажиллах хуваарь

№	Байгууллага	Хугацаа	Гишүүд
2	Үндэсний дата төв УТҮГ	2014.01.16	Б.Мөнхтулга Б.Алтансүх М.Нямтуяа Ш.Хандмаа Р.Алтангэрэл Б.Солонго Э.Хонгорзул
3	Радио телевизийн сүлжээ УТҮГ	2014.01.17	Б.Мөнхтулга Б.Алтансүх М.Нямтуяа Б.Оюунцэцэг Э.Бат-Оюун Б.Бямбасүрэн
4	Мэдээллийн технологийн үндэсний парк	2014.01.20	Б.Мөнхтулга Б.Алтансүх М.Нямтуяа Б.Цэцэг Э.Бямбасүрэн В.Батбаяр Б.Бямбасүрэн

Тав. Тайлагнах

Ажлын хэсэг тушаалд заасан хугацаанд хяналт-шинжилгээний тайлан, санал дүгнэлтээ гаргаж газрын удирдлага /Даргын зөвлөлийн хуралд/ танилцуулна.